



## БАНКНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх багц гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Голомт Банк, нөгөө талаас

**Овог:** .....  
**Нэр:** .....  
**Регистрийн №:** .....

(цаашид “Харилцагч” гэх, хамтад нь “Талууд” гэх) нар Монгол Улсын Иргэний Хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн харилцан тохиролцож байгуулав.

- 1.2. Энэхүү гэрээгээр Банк нь Харилцагчийг бүртгэх, Харилцагчид банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх ерөнхий нөхцөлийг тодорхойлох, Харилцагч Банкны салбар, нэгж болон Банкнаас санал болгож буй зайны сувгуудаар дамжуулан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах харилцааг зохицуулах бөгөөд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, харилцааг тодорхойлно.

### ХОЁР. БАНКНЫ ХАРИЛЦАГЧААР БҮРТГЭХ

- 2.1. Харилцагч нь дараах мэдээллийг Банканд гаргаж өгөх бөгөөд Банк холбогдох мэдээлэл болон баримтыг шалгаж баталгаажуулсны дараа Харилцагчаар бүртгэнэ. Үүнд:
- 2.1.1. Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр;
  - 2.1.2. Регистрийн дугаар;
  - 2.1.3. Гэрийн хаяг;
  - 2.1.4. Холбоо барих утасны дугаар;
  - 2.1.5. Тогтмол ашигладаг, нууцлал бүхий и-мэйл хаяг;
  - 2.1.6. Гарын үсгийн маягт;
  - 2.1.7. Банкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл, баримт бичиг.
- 2.2. Харилцагчаас Банканд гаргаж өгсөн баримт бичгийн хүчин төгөлдөр байдал, мэдээллийн үнэн, зөв, бодит байдлыг Харилцагч бүрэн хариуцна.
- 2.3. Харилцагчийн Банканд бүртгүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд Харилцагч Банкны аль нэг салбар, тооцооны төвд ирж өөрчлөлт орж буй мэдээлэл болон өөрчлөлт орсон болохыг баталгаажуулахад шаардлагатай баримт бичгийг Банканд гаргаж өгөх үүрэгтэй. Уг үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс шалтгаалан бий болох аливаа эрсдэлийг Банк хариуцахгүй.

### ГУРАВ. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

- 3.1. Харилцагч нь энэхүү Гэрээг Банктай байгуулж, Гэрээнд заасны дагуу холбогдох мэдээллийг Банканд гаргаж өгч, Харилцагчаар бүртгэгдснээр Банкнаас санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжтой болно.
- 3.2. Харилцагч нь Банкнаас бүтээгдэхүүн үйлчилгээ авахдаа Банкны салбар, тооцооны төв болон Банкнаас санал болгож буй зайны сувгуудыг ашиглан авч болно.
- 3.3. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг зайны сувгаар үзүүлэх харилцааг Харилцагчтай тусгайлан байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 3.4. Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхдээ тухайн үйлчилгээний нөхцөлийг нарийвчлан зохицуулсан Үйлчилгээний нэмэлт гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх) байгуулахыг Харилцагчаас шаардаж болно. Энэ зүйлд заасны дагуу байгуулах нэмэлт гэрээг талууд бичгээр байгуулна. Бүтээгдэхүүн үйлчилгээг энэ Гэрээний 3.3-т заасны дагуу байгуулсан гэрээний хүрээнд зайнаас үзүүлж байгаа тохиолдолд нэмэлт гэрээг тухайн гэрээнд заасны дагуу байгуулна.



Бүтээгдэхүүн үйлчилгээг зогсоох, татгалзах:

- 3.5. Дараах тохиолдолд Банк гэрээний дагуу Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үзүүлж буй үйлчилгээг зогсоох, холбогдох дансыг хаах арга хэмжээг авч болно. Үүнд:
  - 3.5.1. Харилцагч нь Банканд гаргаж өгвөл зохих мэдээллийг гаргаж өгөөгүй эсхүл хувийн хэргийн бүрдэл дутуу байгаа тохиолдолд;
  - 3.5.2. Харилцагчийн Банканд гаргаж өгсөн мэдээлэл нь хуурамч мэдээлэл болох нь тогтоогдсон;
  - 3.5.3. Харилцагчийн үйл ажиллагаа, гүйлгээ нь Банкны дотоод бодлого, журмын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон;
  - 3.5.4. Харилцагч нь Банкнаас шаардсан нэмэлт мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөхөөс татгалсан;
  - 3.5.5. Харилцагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эсхүл биелүүлэхээс татгалзсан;
  - 3.5.6. Харилцагч нь Банкны нийтэд зарласан болон түүнд танилцуулсан бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа болохоо илэрхийлсэн;
  - 3.5.7. Харилцагч нь Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг 2 болон түүнээс дээш жилийн хугацаанд ашиглаагүй;
  - 3.5.8. Харилцагч нас барсан, ор сураггүй алга болсон эсхүл нас барсан гэж эрх бүхий байгууллагаас тогтоогдсон болохыг нотлох баримтыг Банканд ирүүлсэн;
  - 3.5.9. Эрх бүхий байгууллагаас Харилцагчид үзүүлж буй үйлчилгээг хязгаарлах, зогсоох, битүүмжлэх арга хэмжээг хуульд заасны дагуу авсан;
  - 3.5.10. Аливаа шалтгааны улмаас Банк энэхүү гэрээнд заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг цаашид үзүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон бол энэ тухай Харилцагчид мэдэгдсэнээр;

#### **ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ ТОДОРХОЙЛОХ**

- 4.1. Банк нь Харилцагчид үзүүлэх харилцах данс, хадгаламжийн данс, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа болон тэдгээртэй холбоотой банкны бусад бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтыг тусгасан нөхцөлийг өөрийн цахим хуудас [www.golomtbank.com](http://www.golomtbank.com)-д болон бусад сувгуудаар дамжуулан нийтэд ил тод мэдээлэх бөгөөд уг нөхцөлийг Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний Ерөнхий нөхцөл (цаашид “**Ерөнхий нөхцөл**” гэх) гэж ойлгоно. Ерөнхий нөхцөл нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.2. Харилцагчийн Банкнаас авч буй бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг Ерөнхий нөхцөлд үндэслэн тодорхойлох бөгөөд бусад нэмэлт нөхцөлийг нэмэлт гэрээгээр тодорхойлно.
- 4.3. Банк өөрийн зарласан Ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулж болох бөгөөд холбогдох өөрчлөлтийн тухай мэдээллийг нийтэд ил тод зарлана. Харилцагч нь Ерөнхий нөхцөлд оруулж буй өөрчлөлтийг хүлээн авахаас татгалзах тухай санал гаргаагүй тохиолдолд өөрчлөлт оруулсан нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 4.4. Банк нь хугацаагүй хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ болон төлбөрийн картын аливаа нөхцөлд энэ гэрээний 4.3-т заасны дагуу өөрчлөлт оруулах нөхцөлд энэ тухай 30 /гуч/-с доошгүй хоногийн өмнө нийтэд ил тод зарлана.
- 4.5. Энэ гэрээний 4.3-т заасан Ерөнхий нөхцөлийн өөрчлөлт нь тодорхой төрлийн бүтээгдэхүүнүүдэд хамаарахгүй бөгөөд уг нөхцөлийг тухайн нэмэлт гэрээнд тусгана. Нэмэлт гэрээнд Ерөнхий нөхцөлийг дагаж мөрдөхгүй байх тухай тусгайлан заагаагүй тохиолдолд Ерөнхий нөхцөлийг дагаж мөрдөнө.

#### **ТАВ. ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 5.1. Банк Харилцагчийн өгсөн төлбөрийн даалгаврын дагуу Харилцагчийн харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд байршиж буй мөнгөн хөрөнгийн хэмжээнд орлого, зарлагын бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо хийж гүйцэтгэх үйлчилгээг үзүүлнэ.
- 5.2. Харилцагч нь төлбөрийн даалгаврыг Банкнаас баталсан загварын дагуу бөглөж, баталгаат гарын үсгээр баталгаажуулан Банкны аль нэг салбар тооцооны төв дээр ирж өгөх ба Банк уг төлбөрийн даалгаврын дагуу төлбөр тооцоог гүйцэтгэнэ.




- 5.3. Харилцагч нь төлбөрийн даалгаврыг Банктай байгуулсан гэрээний үндсэн дээр зайны сувгаар дамжуулан өгч болох бөгөөд зайны сувгаар төлбөр тооцоо гүйцэтгэх харилцааг энэ Гэрээний 3.3-т заасны дагуу байгуулагдсан гэрээгээр зохицуулна.
- 5.4. Төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэл, хураамжийг төлбөр тооцоо гүйцэтгэх үеийн Ерөнхий нөхцөлийн дагуу тодорхойлно.
- 5.5. Харилцагч төлбөр тооцоо гүйцэтгэх тухай төлбөрийн даалгаврыг Банканд өгснөөр төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэл, хураамжийг төлөхийг зөвшөөрсөнд тооцох бөгөөд Банк холбогдох шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас суутгаж авна.
- 5.6. Харилцагчийн төлбөрийн даалгавраар хийж буй гүйлгээ нь өөр валютын данс хооронд хийгдэж буй гүйлгээ бол Банк холбогдох гүйлгээг хийж гүйцэтгэхдээ ханшийн хөрвүүлгийг Голомт банкны ханшаар тооцож гүйцэтгэнэ.
- 5.7. Харилцагчийн өгсөн төлбөрийн даалгаврын дагуу төлбөр тооцоо гүйцэтгэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгө байхгүй байх тохиолдолд Банк Харилцагчийн төлбөрийн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзана.
- 5.8. Харилцагчийн төлбөрийн даалгавраар хийж буй гүйлгээ нь өөр банк эсхүл олон улсын байгууллагаар дамжин хийгдэж байгаа тохиолдолд Харилцагч нь тухайн байгууллагаас шаардаж буй үйлчилгээний шимтгэл, хураамжийг Банканд төлнө.

### **ЗУРГАА. ХАРИЛЦАХ ДАНСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 6.1. Банк нь энэ гэрээний дагуу Харилцагчийн нэр дээр данс нээх, Харилцагчийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгө байршуулах, данснаас төлбөр тооцоо гүйцэтгэх, харилцах дансыг хаах үйлчилгээг үзүүлнэ.
- 6.2. Харилцагч харилцах данс нээх, хаах хүсэлтийг Банкны аль нэг салбар, тооцооны төвд өөрийн биеэр хандаж, бичгээр гаргаж өгнө.
- 6.3. Харилцагчийн гаргасан хүсэлт нь зохих шаардлагыг хангасан тохиолдолд Банк харилцах дансыг нээж, дансны дугаар болон бусад нөхцөлийг тусгасан нэмэлт гэрээг Харилцагчтай байгуулна.
- 6.4. Харилцагч тодорхой төрлийн данс нээх, хаах тухай хүсэлтийг зайнаас гаргаж болох бөгөөд зайны сувгаар дамжуулан авч болох харилцах данстай холбоотой үйлчилгээг энэ Гэрээний 3.3-т заасны дагуу байгуулагдсан гэрээгээр зохицуулна.
- 6.5. Харилцах дансны үйлчилгээний шимтгэл хураамжийг Ерөнхий нөхцөлөөр тодорхойлох ба харилцах дансны үйлчилгээний шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас суутгаж авна.
- 6.6. Банк нь Харилцагчийн нэр дээр нээгдсэн аливаа харилцах дансанд банкны цахим хуудсанд байршуулсан нөхцөлийн дагуу хүү бодож олгоно.

### **ДОЛОО. КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

- 7.1. Банк нь энэхүү гэрээний хүрээнд Харилцагчид биет болон биет бус дебит картын үйлчилгээг үзүүлнэ.
- 7.2. Харилцагчаас Банканд олгох карт нь хугацаатай байх бөгөөд Харилцагч нь картын хүчинтэй хугацааны туршид тухайн картыг эзэмшиж, зохих төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.
- 7.3. Картын үйлчилгээний шимтгэл хураамжийг Ерөнхий нөхцөлөөр тодорхойлно.
- 7.4. Дебит карт шинээр захиалах, нөхөж авах, картыг хугацааг сунгуулах, картаар төлбөр тооцоо хийж гүйцэтгэх болон картын үйлчилгээтэй холбоотой бусад шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутгаж төлүүлнэ.
- 7.5. Харилцагчийн дебит картаар хийгдсэн бүх гүйлгээг Харилцагч хариуцна. Харилцагч нь өөрийн дебит картаар хийгдэж буй гүйлгээнд тогтмол хяналт тавих үүрэгтэй ба хэрэв Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр картаар дамжуулан гүйлгээ хийгдсэн тохиолдолд энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэж, картын гүйлгээг хаалгах үүрэгтэй.
- 7.6. Олон улсын эрхтэй картаар картаар бусад валютаар төлбөр тооцоо хийхэд картын төрөл, гүйлгээ нэхэмжлэгдсэн өдрийн ханш, тухайн картаар үйлчлэгч байгууллагын банкны ханш, “Виза Интернэйшнл”, “Мастеркарт Ворлдвайд”, “ЮнионПэй Интернэйшнл”, “Американ Экспресс” байгууллагуудын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан гүйлгээний ханш тооцогдоно.

- 
- 7.7. Картаар төлбөр тооцоо хийхдээ төлбөр тооцоо хийх нөхцөлтэй сайтар танилцах үүрэгтэй ба дебит картын валютаас өөр валютаар гүйлгээ хийх, өөр банкны сүлжээ болон гадаад улсын картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан төлбөр тооцоо хийхтэй холбоотой гарах нэмэлт зардлыг Харилцагч хариуцна.
  - 7.8. Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд луйврын гүйлгээний эрсдэл болон карттай холбоотой бусад эрсдэлээс сэргийлэх зорилгоор Харилцагчийн дебит картын гүйлгээний эрхийг хязгаарлах арга хэмжээг авч болно. Үүнд:
    - 7.8.1. Картаар хийгдэх бэлэн болон бэлэн бус гүйлгээний өдрийн дээд хэмжээ, гүйлгээний тоог бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлд заасны дагуу хязгаарлана.
    - 7.8.2. Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд Олон улсын байгууллага болон Монгол улсын эрх бүхий байгууллагаас баталсан хууль, дүрэм, журам гэх мэт баримт бичгүүдэд тодорхойлсон, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглосон улс орон, иргэн, хуулийн этгээдээр дамжуулан төлбөр тооцоо хийсэн гэж үзсэн тохиолдолд Банк тухайн төлбөр тооцоог хийхээс татгалзах, төлбөр тооцоог зогсоох арга хэмжээг авч болно.
    - 7.8.3. Эрсдэлтэй, луйврын шинжтэй гүйлгээ байж болзошгүй гэж үзсэн гүйлгээнд хязгаарлалт тогтооно.
    - 7.8.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулдаг газар хийгдэх гүйлгээг хориглоно.
    - 7.8.5. Харилцагч нь пин кодоо 3 удаа буруу оруулсан тохиолдолд картын гүйлгээ нь тухайн өдрийн турш хаагдана.
  - 7.9. Гэрээний 7.8-д заасан хязгаарлалтаас болж гүйлгээ саатсан, гүйлгээ цуцлагдсанаас шалтгаалан бий болсон нэмэлт зардал, Харилцагчид учирсан хохирлыг Банк хариуцахгүй.
  - 7.10. Харилцагч нь дараах шалтгаанаас үүссэн эрсдэлийн хариуцлагыг бүрэн хүлээнэ. Үүнд:
    - 7.10.1. Картын дугаар, карт эзэмшигчийн нэр, картын хүчинтэй хугацаа, картын пин код, интернэт худалдаанд ашиглах код, CVV код болон картын соронзон тууз, нууцлал бүхий чипэнд хадгалагдаж буй мэдээллийг Харилцагч нууцлах үүргээ зөрчсөн эсхүл эдгээр мэдээллийг бусдад алдсан, дамжуулсны улмаас хийгдсэн луйврын гүйлгээ;
    - 7.10.2. Картын мэдээллийг бусдад алдсан байж болох тухай эрсдэлийг банканд мэдэгдэх арга хэмжээг аваагүйгээс шалтгаалсан эрсдэл;
    - 7.10.3. Картын гүйлгээнээс шалтгаалан бий болсон валютын ханшийн зөрүүнээс бий болсон зардал;
    - 7.10.4. Зөвшөөрөлгүй хийгдсэн гэх гүйлгээний мэдээллийг 14 хоногийн дотор банканд мэдэгдэх үүрэгтэй ба үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн гарах эрсдэл;
    - 7.10.5. Банкинд бүртгэлтэй мэдээллээ шинэчлээгүй, өөрчлөлт орсон даруйд мэдэгдээгүйн улмаас банк Харилцагчтай холбогдож чадаагүй эрсдэл;
    - 7.10.6. Карт хүлээн авагч байгууллагын тавьсан шаардлагаас шалтгаалан Харилцагчийн картыг хүлээн авахаас татгалзах, картыг уншихгүй байгаагаас шалтгаалан бий болох эрсдэл.
  - 7.11. Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой банк, Харилцагч болон банкны гэрээт үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсхүл хүлээн авагчийн хооронд үүссэн маргаантай асуудлыг Харилцагч, үйлчилгээний байгууллага эсхүл хүлээн авагчийн аль нэг талын хүсэлтээр гурван талын оролцоотойгоор хамтран зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.
  - 7.12. Гадаад улсад төлбөрийн картаар хийгдсэн аливаа маргаантай гүйлгээг шийдвэрлэх үйл ажиллагаа нь “Виза Интернэйшнл”, “Мастеркарт Ворлдвайд” “ЮнионПэй Интернэйшнл”, “Американ Экспресс” байгууллагуудын Маргаан шийдвэрлэх Олон улсын дүрмүүд болон Голомт банкны журмаар зохицуулагдана. Гомдлыг шийдвэрлэх Ерөнхий хугацаа нь хүсэлт гаргасан өдрөөс хойш 180 хоног байх бөгөөд тухайн маргааны төрлөөс шалтгаалан холбогдох журамд заасны дагуу тодорхойлогдоно.
  - 7.13. Дотоодод төлбөрийн картаар хийгдсэн аливаа маргаантай гүйлгээг шийдвэрлэх үйл ажиллагаа нь Монгол банкнаас гаргасан журам болон Голомт Банкны журам заавраар зохицуулагдана. Гомдлыг шийдвэрлэх ерөнхий хугацаа нь хүсэлт гаргасан өдрөөс хойш 60 хоног байх бөгөөд тухайн маргааны төрлөөс шалтгаалан холбогдох журамд заасны дагуу тодорхойлогдоно.
  - 7.14. Талууд гэрээний 7.13, 7.14-т заасны дагуу хэлцэлд хүрч, маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гадаадад хийгдсэн гүйлгээний хувьд олон улсын арбитерт, дотоодод хийгдсэн гүйлгээний хувьд Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын Шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

Карт шинээр захиалах, нөхөн авах, карт сунгуулах, карт хаах



- 7.15. Харилцагч шинээр биет карт захиалах, карт нөхөн авах, картын хугацааг сунгах, карт хаах хүсэлтийг Банкны аль нэг салбар тооцооны төв дээр өөрийн биеэр ирж гарна.
- 7.16. Харилцагчийн картын зарим үйлчилгээг банкнаас зөвшөөрсөн зайны сувгаар дамжуулан авч болох бөгөөд уг харилцааг энэ Гэрээний 3.3-т заасны дагуу байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 7.17. Карт шинээр олгох, картын хугацаа сунгахдаа олгож буй картын дугаар болон тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй картын үйлчилгээний ерөнхий нөхцөлийг тодорхойлсон нэмэлт гэрээг байгуулна.
- 7.18. Харилцагч карт шинээр захиалах, картын хугацаа сунгах хүсэлтийг Банкны салбар тооцооны төв дээр ирж гаргасан бол нэмэлт гэрээг бичгээр байгуулна.
- 7.19. Карт хаах хүсэлтийг Харилцагч банкны аль нэг салбар тооцооны төв дээр өөрийн биеэр ирж болон зөвшөөрөгдсөн зайны сувгаар дамжуулан гаргаж болох ба Банк Харилцагчийн хүсэлтийн дагуу картыг хаана.

### НАЙМ. ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 8.1. Банк нь энэ гэрээний дагуу Харилцагчийн нэр дээр хадгаламжийн данс нээх, Харилцагчийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг хадгалах, дансанд хадгалагдаж буй мөнгөн хөрөнгөнд хүү тооцож олгох үйлчилгээг үзүүлнэ.
- 8.2. Хадгаламжийн бүтээгдэхүүн нь хугацаагүй болон хугацаатай гэсэн үндсэн төрөлтэй байна.
- 8.3. Банк нь хадгаламжийн бүтээгдэхүүний дэд төрөл болон тэдгээрийн нөхцөлийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд ил тод мэдээлэх бөгөөд уг нөхцөлүүд нь Ерөнхий нөхцөлийн салшгүй нэг хэсэг байна.

Хугацаатай хадгаламжид мөрдөх ерөнхий нөхцөл


- 8.4. Хугацаатай хадгаламжийн хүүг хугацааны эцэст бодож, мөнгөн хадгаламжид оруулна.
- 8.5. Хэрэв урьдчилж хүү олгох нөхцөлтэй хадгаламж бол сар бүрийн хүүг хадгалуулагчийн тодорхойлсон дансанд олгож байна. Тухайн хадгаламжийн нөхцөлд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хугацаатай хадгаламжийн хүү хүлээн авах данс нь уг хадгаламжийн данснаас өөр данс байна.
- 8.6. Харилцагч хадгаламжийн хугацаа дуусгавар болохоос өмнө зарлага гаргах тохиолдолд гэрээг цуцалж, данс хаагдах ба данс нээсэн эсхүл хугацаа сунгасан өдрөөс цуцлаж байгаа өдрийг хүртэл хугацаанд хямдруулалтын хүү тооцож олгоно. Хямдруулалтын хүүг нэмэлт гэрээгээр тодорхойлно.
- 8.7. Хадгаламжийн хугацаа дууссан өдөр Харилцагч хадгаламжийн хугацааг сунгах хүсэлт тавиагүй бол тухайн өдрөөс эхлэн уг мөнгөн хадгаламжийг хугацаа дууссан төлөвт шилжүүлж, хугацаагүй хадгаламжийн хүү тооцно.

Хугацаагүй хадгаламжид мөрдөх ерөнхий нөхцөл

- 8.8. Хугацаагүй хадгаламжийн хүүг өдөр бүр хуримтлуулах бөгөөд хуанлийн жилийн эцсийн өдөр тухайн хадгаламжийн дансанд олгоно. Хэрэв Харилцагч хадгаламжийн дансаа хааж байгаа тохиолдолд тухайн өдөр хүртэл хуримтлагдсан хүүг бодож олгоно.
- 8.9. Хэрэв сар бүр хүү олгох нөхцөлтэй хадгаламж бол сар бүрийн эцэст тухайн сарын хүүг тооцож мөнгөн хадгаламжийн дансанд олгоно.
- 8.10. Хугацаагүй хадгаламжийн хүүгийн нөхцөлийг хадгаламж нээх үеийн Ерөнхий нөхцөлөөр тодорхойлно. Банк өөрийн нийтэд зарласан хугацаагүй хадгаламжийн хүүгийн хэмжээгээ өөрчлөх тохиолдолд энэ гэрээний 4.3-т заасныг баримталж, холбогдох өөрчлөлтийн талаар 30-с доошгүй хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлнэ.

Хадгаламжийн бусад нөхцөл

- 8.11. Хадгаламжийн нэг өдрийн хүүг тооцохдоо жилийн хүүг 365 хоногт хувааж, нийт хүүг тооцохдоо хадгалуулсан хоногоор үржүүлж тооцно.

- 
- 8.12. Харилцагч нь хадгаламжийн хүүг өөр дансанд авах бол энэ тухай Банканд урьдчилан мэдэгдэх шаардлагатай.
  - 8.13. Харилцагч хадгаламжийн данс нээх, хадгаламжийн хугацааг цуцлах, сунгах, хадгаламжийн дансыг хаах хүсэлтийг Банканд өөрийн биеэр ирж гаргах бөгөөд хадгаламжийн данс нээх бүртгээ Банктай нэмэлт гэрээ байгуулна.
  - 8.14. Харилцагч нь тодорхой төрлийн хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээ авах тухай хүсэлтийг зайны сувгаар дамжуулан гаргаж болох ба зайны сувгаар хадгаламж нээх харилцааг энэ Гэрээний 3.3-т заасан гэрээгээр зохицуулна.
  - 8.15. Хадгаламжийн дансны үйлчилгээний шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас суутгаж төлүүлнэ.
  - 8.16. Харилцагч нь Банктай байгуулсан аливаа гэрээ хэлцлийн дагуу өөрийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн данснаас үүргийн гүйцэтгэл хангуулах, төлбөр гүйцэтгэх тухай зөвшөөрлийг өгч болох ба уг зөвшөөрлийн дагуу хийсэн аливаа гүйлгээг Харилцагчийн төлбөрийн даалгавраар хийсэн гүйлгээнд тооцно. Энэ зүйлд заасны дагуу хугацаатай хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ хийгдэх тохиолдолд Харилцагчийн хүсэлтийн дагуу хадгаламжийн хугацааг цуцалсанд тооцож, хадгаламжийн хүүг хямдруулалтын хүүгээр тооцно.

## ЕС. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 9.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 9.1.1. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, нөхцөл, шимтгэлийн талаар Харилцагчид үнэн зөв мэдээллийг хүргүүлэх;
  - 9.1.2. Харилцагчийн төлбөр тооцоог хүлээн авсан дарааллын дагуу үнэн зөв гүйцэтгэх;
  - 9.1.3. Харилцагчийн хувийн мэдээлэл, данс, картын дугаар болон гүйлгээний талаарх мэдээллийг Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд үл задруулах, нууцлалыг хадгалах;
  - 9.1.4. Гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан Ерөнхий нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай нийтэд мэдээллэх;
  - 9.1.5. Шүүх, прокурор, цагдаа, татварын байгууллага болон хууль тогтоомжийн дагуу үл маргах журмаар төлөх төлбөрөөс бусад тохиолдолд Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас зарлагын гүйлгээ хийхгүй байх;
  - 9.1.6. Харилцагчийн дансны хуулга, гүйлгээ, үлдэгдлийн талаарх мэдээллийг Харилцагчийн хүсэлтийг үндэслэж, банкны дотоод заавар журмын дагуу Харилцагчид олгох;
  - 9.1.7. Бусад гадаадын болон дотоодын банкны сүлжээнд гарсан маргаантай гүйлгээний асуудлыг Харилцагчийн хүсэлтэд үндэслэн, Харилцагчийг төлөөлөн шийдвэрлүүлэх;
  - 9.1.8. Банк Харилцагчийн картын гүйлгээний мэдээллийг дараах сувгуудаар дамжуулан үнэ төлбөргүй хүргэх үүрэгтэй. Үүнд:
    - 9.1.8.1. Баталгаат и-мэйл хаяг;
    - 9.1.8.2. Интернет банк;
    - 9.1.8.3. Смарт банк;
    - 9.1.8.4. Сошиал Пэй;
    - 9.1.8.5. Мобайл банк;
- 9.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:
  - 9.2.1. Ерөнхий нөхцөлд энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу өөрчлөлт оруулах;
  - 9.2.2. Харилцагчийн данснаас бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэлийг Ерөнхий нөхцөл болон нэмэлт гэрээнд заасны дагуу үл маргах журмаар суутган авах;
  - 9.2.3. Харилцагч АТМ, СДМ-д хураагдсан болон шинээр захиалсан картаа 3 сарын дотор банкнаас аваагүй тохиолдолд картыг устгах;
  - 9.2.4. Банкны системийн доголдол, техникийн саатлаас үүдэн Харилцагчийн картанд давхар болон илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн дүнгээр банканд дах Харилцагчийн аливаа данснаас үл маргах журмаар суутгах;
  - 9.2.5. Банк луйврын гүйлгээний эрсдэлээс сэргийлэх зорилгоор картаар болон дижитал сувгаар гарсан сэжигтэй гүйлгээг хянаж, Харилцагчтай холбогдож баталгаажуулах, холбогдож чадаагүй





тохиолдолд банкны зүгээс карт болон интернэт банкны эрхийг Харилцагчтай холбогдох хүртэл хаах;

- 9.2.6. Харилцагчийн хийсэн төлбөр тооцооны үнэн зөв эсэхэд эргэлзсэн, хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эсхүл алдаатай, илүү, дутуу болон давхар хийсэн аливаа маргаантай гүйлгээг (цаашид “Маргаантай гүйлгээ” гэх) шийдвэрлэхийн тулд Маргаантай гүйлгээний дүнгээр холбогдох дансанд түр хаалт тавих, маргаантай гүйлгээнд Харилцагчийн буруутай үйлдэл нотлогдвол түүний данснаас хохирол, зардлыг үл маргах журмаар суутган авах;
  - 9.2.7. Харилцагчийн буруугаас шалтгаалан Банканд хохирол учирсан бол Харилцагчийн банкин дахь данснаас хохирлыг үл маргах журмаар суутган авах, дансны үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
  - 9.2.8. Дансны үлдэгдлээ санаатай болон санамсаргүй дансны боломжит үлдэгдлээс хэтрүүлэн ашигласан тохиолдолд Ерөнхий нөхцөлд заасны дагуу хүү, шимтгэл, бусад төлбөрийг төлж барагдуулахыг шаардах, бусад данснаас суутган авах, төлбөрийг төлүүлэх талаар хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
  - 9.2.9. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Харилцагчийн дансанд олгогдох хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварыг суутгаж, холбогдох татварын байгууллагад шилжүүлэх;
  - 9.2.10. Банк нь өөрийн дотоод журам, үйлчилгээний нөхцөлийн дагуу Харилцагчийн Банканд бүртгэлтэй мэдээллийг тодорхой давтамжтайгаар шалгаж, баталгаажуулах ажиллагааг хийж болох ба Харилцагчаас өөрийн мэдээллийг шинэчилж өгөх, эсхүл шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт мэдээллийг шаардаж авах эрхтэй;
  - 9.2.11. Энэхүү гэрээнд заасны нөхцөл бий болсон тохиолдолд Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үзүүлж буй үйлчилгээг түр зогсоох эрхтэй.
- 9.3. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 9.3.1. Банкны цахим хуудсанд нэвтэрч Ерөнхий нөхцөлтэй тогтмол танилцаж байх үүрэгтэй;
  - 9.3.2. Банкаар үйлчлүүлэхдээ шаардлагатай баримт бичиг, хурууны хээний баталгаажуулалт болон бусад мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх ба мэдээлэл өөрчлөгдөх бүрт банкны тавьсан нөхцөлийн дагуу мэдэгдэж тухай бүр шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас банк болон Харилцагчид учирсан аливаа хохирлыг бүрэн хариуцах;
  - 9.3.3. Харилцагч нь Банкнаас олгосон картын дугаар, пин коп, и-код, CVV дугаар болон өөрийн интернэт банкны нэвтрэх нэр, нууц уг болон бусад нууцад хамаарах мэдээллээ чандлан сахих;
  - 9.3.4. Картын пластик, картын дугаар, хүчинтэй хугацаа, пин код, и-код, CVV код, соронзон туузны мэдээлэл, интернэт банкны нэвтрэх нэр, нууц уг болон бусад баталгаажуулалтын хэлбэрийг бусад дамжуулсан, задруулсан, алдсан, нууцлалын төхөөрөмжийг гээсэн, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд банканд нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг хариуцах;
  - 9.3.5. Харилцагч банкнаас авах бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хүлээн авах өөрийн баталгаат и-мэйл хаяг, гар утасны дугаарыг банканд бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрт өөрчлөлт орсон тухай бүр банканд мэдэгдэх, хүлээн авсан мэдээллийн нууцлалыг хангах, нууцлал алдагдсантай холбоотой үүссэн аливаа эрсдэлийг хариуцах;
  - 9.3.6. Харилцагч гүйлгээний баталгаажуулалтын мэдээллийг мартсан, буруу оруулсны улмаас гүйлгээ саатсантай холбоотой аливаа хохирлыг бүрэн хариуцах;
  - 9.3.7. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилан мэхлэх болон гэрээгээр хүлээсэн үүргийг зөрчих замаар банканд хохирол учруулсан бол хохирлыг дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар төлөх;
  - 9.3.8. Данс түүнтэй холбоотой карт эзэмшигч, картаар үйлчлэгч байгууллага, карт гаргагч болон картаар үйлчлэгч банкны аль нэг талаас үл зөвшөөрөн маргаан үүсгэсэн карт болон дансны гүйлгээ шалгах явцад Харилцагч нь гэрээгээр хүлээсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан хохирол, зардлыг бүрэн хариуцах;



- 9.3.9. Картаар Харилцагчийн зөвшөөрөлгүй гүйлгээ гарсан бол гүйлгээний талаарх мэдээллийг гүйлгээ гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор банканд мэдэгдэх, картын гүйлгээний баримт болон банкны шаардсан бусад шаардлагатай баримт бичгүүдийг банканд гаргаж өгөх;
  - 9.3.10. Харилцагч нь Монгол улс болон тухайн улсын засгийн газар хооронд давхар татварын гэрээ байгуулсан гадаад улсын иргэн бол банк хүүгийн орлого олгохоос ажлын 3 хоногийн өмнө татвар төлөгчийн сертификат (тухайн татварын жилд хамаарах), гадаад паспортыг банканд өгснөөр давхар татварын гэрээнд заасан хэмжээгээр татвар суутгуулах;
  - 9.3.11. Хэрэв гэрээний 9.3.10-т зааснаар хүүгийн орлого авахаас өмнө татвар төлөгчийн сертификат, гадаад паспортыг банканд өгөөгүй бол хүүгийн орлогыг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу суутгуулах;
  - 9.3.12. Харилцагч нь Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх)-ын харьяат иргэн бол, эсхүл АНУ-тай холбоо хамааралтай тохиолдолд Банкны FATCA-W-9 эсхүл FATCA-W-8 маягтыг бөглөж, өөрийн болон дансны мэдээлэл, TIN, SSN, EIN дугаарын аль нэгийг АНУ-ын Internal Revenue Service (цаашид “IRS” гэх)-д мэдээлэх зорилгоор Банканд мэдэгдэх үүрэгтэй. Эдгээр мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзах тохиолдолд Банк нь Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно.
  - 9.3.13. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг зохицуулж буй хууль тогтоомжийн хүрээнд Банк нь Харилцагчаас нэмэлт мэдээлэл, баримт бичгийг шаардаж болох бөгөөд Харилцагч шаардсан мэдээлэл болон бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.
- 9.4. Харилцагч дараах эрх эдэлнэ. Үүнд:
- 9.4.1. Гүйлгээний баримт, дансны хуулга, дансны тодорхойлолт, дансны мэдээллийг Банкнаас гаргуулан авах;
  - 9.4.2. Банканд бичгээр хүсэлт гарган, данс хамтран эзэмшигч нэмэх, нотариатаар баталгаажуулсан гэрээслэл, өвлөх эрхийн гэрчилгээ болон итгэмжлэлээр өөрийн өв залгамжлагч болон данс ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойлох;
  - 9.4.3. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан зардал, хохирлыг банкаар төлүүлэх;
  - 9.4.4. Харилцагч өөрийн мэдээлэл болон төлбөр тооцоотой холбоотой мэдээллийг тухай бүр авах хүсэлт гаргах;
  - 9.4.5. Банк Харилцагчийн хурууны хээний мэдээллийг хадгалдаггүй бөгөөд Харилцагч нь “ХУР/ДАН Төрийн мэдээлэл солилцооны систем” –ыг ашиглан төлбөр тооцоо гүйцэтгүүлэх болон бусад үйлчилгээг хурууны хээгээр баталгаажуулан авах;
  - 9.4.6. Харилцагч нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гомдол, санал хүсэлт гаргах;
  - 9.4.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг банкнаас шаардах, хуульд заасан бусад эрх эдлэх.
- 9.5. Харилцагч нь энэхүү гэрээг байгуулж байгаатай холбогдуулан дараах зөвшөөрөл, баталгааг Банканд гаргаж байна. Үүнд:
- 9.5.1. Харилцагч нь энэхүү гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж, гэрээ байгуулсантай холбогдуулан бий болох хууль, эрх зүйн үр дагаврыг бүрэн ойлгосон болно.
  - 9.5.2. Харилцагч нь энэхүү гэрээнд заасны дагуу Банкнаас санал болгож буй аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ авахдаа Ерөнхий нөхцөлийг баримтлах болохыг ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно.
  - 9.5.3. Харилцагч нь Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авсантай холбогдуулан төлбөл зохих үйлчилгээний шимтгэл, хураамжийг Ерөнхий нөхцөлийн дагуу төлөхийг үүгээр зөвшөөрч байгаа бөгөөд холбогдох шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас суутган авахыг Банканд даалгаж/зөвшөөрч байна.

#### **АРВАН ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

- 10.1. Талууд энэхүү гэрээг хугацаагүйгээр байгуулсан болно.
- 10.2. Дараах тохиолдолд гэрээг дуусгавар болсонд тооцно. Үүнд:
  - 10.2.1. Харилцагчийн зүгээс энэхүү гэрээг цуцлах тухай хүсэлт гаргаж, гэрээний дагуу Банкнаас үзүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдуулан бий болсон төлбөр тооцоо дуусгавар болсон.
  - 10.2.2. Энэ гэрээний 3.5-д заасан нөхцөл байдал бий болсноос хойш Харилцагч нь тухайн нөхцөл байдлыг арилгах арга хэмжээ аваагүй бол Банк нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцалж болно.





- 10.3. Энэ гэрээний 10.2.2-т заасны дагуу гэрээг Банкны санаачлагаар цуцалж байгаа тохиолдолд тухайн Харилцагчийн дансанд байгаа мөнгөн хөрөнгийг Харилцагч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нар ирэх хүртэл хугацаанд Харилцагчтай байгуулсан гэрээ болон хуульд заасан нөхцөлийн дагуу Харилцагчийн мөнгөн хөрөнгийг хадгална.
- 10.4. Энэ гэрээний 10.3-т заасны дагуу хадгалж буй мөнгөн хөрөнгөөс Харилцагчийн Банктай байгуулсан гэрээ болон хуульд заасан үндэслэлээр суутгавал зохих шимтгэл, хураамж болон бусад төлбөрийг суутган авч болно.

#### АРВАН НЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 11.1. Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой банк, Харилцагч болон банкны гэрээт үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсхүл хүлээн авагчийн хооронд үүссэн маргаантай асуудлыг Харилцагч, үйлчилгээний байгууллага эсхүл хүлээн авагчийн аль нэг талын хүсэлтээр 3-н талын оролцоотойгоор хамтран зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.
- 11.2. Харилцагчийн төлбөрийн картаар хийж гүйцэтгэсэн төлбөр тооцоотой холбоотой маргааныг энэ Гэрээний 7.13, 7.14-т заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11.3. Хэрэв гэрээний **11.1 болон 11.2**-д зааснаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол улсын хуулийн дагуу, Монгол улсын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 11.4. Талуудын хооронд үүссэн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй, буруутай тал нь тогтоогдоогүй байхад Банкны нэр хүндэд халдах, гутаах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээ тараахыг хориглоно. Үүний улмаас Банканд учирсан хохирлыг Харилцагч бүрэн хариуцаж барагдуулна.

#### АРВАН ХОЁР. БУСАД

- 12.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцогдох ба гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 12.2. Энэхүү гэрээг хугацаагүйгээр байгуулах бөгөөд Харилцагч дансаа хаалгах болон тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс татгалзаж 2 талын зөвшөөрлөөр цуцалсан тохиолдолд гэрээ дуусгавар болно.
- 12.3. Харилцагч төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхэд тухайн цаг хугацаанд банкнаас зарласан арилжааны ханш, олон улсын сүлжээг ашиглах тохиолдолд тухайн үеийн хүү, шимтгэл, ханшийг хүлээн зөвшөөрч, гүйлгээ хийхийг талууд үүгээр харилцан тохиролцов.
- 12.4. Талууд карт ашиглан хийсэн гүйлгээний цахим, цаасан баримт болон тэдгээрийн хуулбарууд мөн гүйлгээтэй холбоотой бусад баримт бичгүүдийг маргаан шийдэх үед нотлох баримт гэж хүлээн зөвшөөрнө.
- 12.5. Аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд хавсралт байдлаар тусгах бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.

#### ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

**Банкийг төлөөлж:**

Овог, нэр: .....(DOMAIN)

Гарын үсэг:.....

(Тэмдэг)

**Харилцагч:**

Овог, нэр: .....

Баталгаат гарын үсэг: .....



**Огноо:** .....

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ – ИНТЕРНЭТ БАНК**  
/Гүйлгээний эрх нэмэгдүүлэх/

Харилцагч: .....  
Регистр: .....

1. Энэхүү Үйлчилгээний нэмэлт гэрээг Харилцагч болон Банкны хооронд байгуулагдсан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээний хүрээнд Харилцагчийн гаргасан хүсэлтийн дагуу харилцан тохиролцож байгуулав.
2. Банк Харилцагчийн гаргасан хүсэлтийн дагуу Интернет банкны үйлчилгээний дараах эрхийг нэмэлтээр олгож байна. Үүнд:

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр	Эрхийн төрөл	Нэвтрэх нэр	Утасны дугаар	Имэйл хаяг
<b>ИНТЕРНЭТ БАНК</b>		<b>(((O)))</b> (программаас татагдах)	.....	.....
<u>Бүх төрлийн гүйлгээ хийх, бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжтой.</u>				
<u>Харилцагчийн одоо ашиглаж байгаа болон цаашид нээх бүх данс /хамтран эзэмшдэг данс/ интернет банкны үйлчилгээнд автоматаар нэмэгдэнэ.</u>				
<u>СМАРТ БАНК: 20 сая төгрөг хүртлэх өдрийн гүйлгээний лимиттэй Смарт банкны үйлчилгээг ухаалаг утсаа ашиглан авах боломжтой.</u>				
<ul style="list-style-type: none"> <li>- 3 сая хүртлэх дүнтэй гүйлгээ 24x7цаг горимоор автомат буюу онлайн хийгдэнэ.</li> <li>- 3 сая-с дээш дүнтэй гүйлгээ ажлын өдрийн 09:00-16:00, Валтын гүйлгээ нь дүнгээс үл хамааран 09:00-18:00, S.W.I.F.T гүйлгээ ажлын өдрийн 09:00-16:30 цагийн хооронд хийгдэх ба үүнээс хойш хийгдсэн гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэнэ.</li> </ul>				

3. Интернет банкны үйлчилгээний бусад нөхцөл нь Банкны Ерөнхий нөхцөл болон Харилцагчийн Банктай байгуулсан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээ болон Дижитал банкны үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зохицуулагдана.
4. Банк нь Интернет банкны үйлчилгээний нөхцөлд нэг талын санаачлагаар өөрчлөлт оруулж болох бөгөөд өөрчлөлтийн талаар өөрийн цахим хуудас болон бусад сувгаар дамжуулан 30-с доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээллэсэн байна.

**Банкийг төлөөлж:**

Овог, нэр: ..... (DOMAIN)

Гарын үсэг: .....  
(Тэмдэг)

**Харилцагч:**

Овог, нэр: ..... (.....)

Баталгаат гарын үсэг: .....